



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/79

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тасралтгүй тэжээлийн системийн сэлбэг нийлүүлэх Багц-3: Тасралтгүй тэжээлийн төхөөрөмж ETUS-40kVA UPS-ийн сэлбэг нийлүүлэх ИНЕГ/УЗ/ТББ/Б-75/20-135/20 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:
Ж.Батбэх

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холимог тэжээл, цахилгааны хэсгийн дарга

Гишүүд:
Ц.Баяраа

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холимог тэжээл, цахилгааны хэсгийн холимог тэжээлийн ахлах инженер

Л.Баярмаа

Аюулгүй байдал, хамгаалалтын албаны Тоног төхөөрөмжийн хэсгийн тоног төхөөрөмжийн инженер

Э.Энхжин

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Х.Наранцацрал

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээж авах комисс (Ж.Батбэх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0766